

## Христийн гэрэл хүн бүрийн дотор байдаг

Ням гаргийн хичээл дээр танаас бүх хүнийг, ялангуяа өөрөөсөө ялгаатай хүмүүсийг илүү ойлгож, харьцах талаар бодлоо товч хуваалцахыг хүссэн гэж төсөөлөөд үз. Та нар дараах болон өөрт хэрэгтэй гэж үзсэн бусад эх сурвалжийг ашиглаж болно.

Сургаал ба Гэрээ 88:11

Сургаал ба Гэрээ 93:2

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ерөнхийлөгч Боид К.Пакэр (1924–2015) ийн заасан.



Бид Христийн гэрлийн талаар мэдэх тусам амьдралыг улам илүү ойлгож, бүх хүн төрөлхтнийг илүү их хайрлах болно. Бид илүү сайн багш, номлогч, эцэг эх, эрэгтэй, эмэгтэй мөн хүүхдүүд байх болно. Бид Сүм дэх ах, эгч, дүү нараа болон итгэдэггүй хүмүүсийг ч илүү гүн гүнзгий хүндэтгэх болно. . . .

Христийн гэрэл нь нарны гэрэл шиг түгээмэл зүйл юм. Хүний амьдрал хаана байна, тэнд Христийн Сүнс байдаг. Аливаа амьд бодгаль бүр үүнийг эзэмшдэг. . . .

Хэрэв бид уулзах хүн бүрийнхээ хийгээд . . . өөрсдийнхөө дотор байдаг . . . Христийн гэрлийн бодит байдлыг ойлговол урьд өмнө мэддэг байснаасаа илүү урам зоригтой, хүсэл тэмүүлэлтэй байх болно. Ийм л байх *ёстой!* Ийм ч байх *болно!* Энэ бүхэн нь сайн мэдээний үнэний хэмжээс ба дэндүү цөөн хүн үүнийг ойлгодог. (Boyd K. Packard, "The Light of Christ," *Ensign*, Apr. 2005, 8, 13–14)

Христийн гэрлийг ойлгох нь бусдыг харах өнцөгт тань хэрхэн нөлөөлөх талаар 2-оос 3 өгүүлбэр бич.

## Орчлон ертөнц дэх Христийн гэрэл

Та нар хэзээ нэгтгээ энэ дэлхийн буюу орчлон ертөнцийн гоо үзэсгэлэн, сүр жавхланд сэтгэл тань хөдөлж байсан уу? Эдгээр нь та нарт ямар мэдрэмж төрүүлдэг вэ?

Сургаал ба Гэрээ 88:7–10, 45–47-г уншаад, Христийн гэрэл, дэлхий, орчлон ертөнцийн талаар юу сурч болохыг олж мэд.

- Бид Их Эзэний бүтээлтээс Түүний талаар юу мэдэж авч болох вэ?
- Орчлон ертөнц дэх Бурханы нөлөөг харах нь үүнийг амьдралдаа таньж мэдэхэд бидэнд хэрхэн тусалж чадах вэ?